

**ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДСЭН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ
МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТАНИН МЭДЭХҮЙН
ТУСГАЙ МЭДЛЭГ АШИГЛАХ НЬ**

**INVESTIGATION OF FRAUD CRIMES COMMITTED IN THE ELECTRONIC ENVIRONMENT
FUNDAMENTAL THEORIES AND LEGAL PROBLEMS**

П.Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын
эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

P.Erdenebaatar

Senior teacher of Department Criminal Procedure Law,
Police Lieutenant Colonel, Police school of University
of Internal Affairs

Хураангуй: Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд мэдээллийн өндөр технологи, компьютерын техникийн тусгайлсан танин мэдэхүйн салбарын тусгай мэдлэгийг ашиглах талаар авч үзсэн болно.

Abstract: The application of advanced information technology and specialized computer science expertise in the investigation of cyber fraud is discussed.

Түлхүүр үгс: Мөрдөн шалгах ажиллагаа, шинжээч томилох, мэргэжилтэн, шинжээч, тусгай мэдлэг, тусгайлсан танин мэдэхүй

Keywords: Investigation, appointment of experts, specialist, experts, special knowledge, special knowledge.

Үндсэн хэсэг. Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлогийн тухай эрдэмтэн судлаачдын бүтээлүүд олон байгаа хэдий ч энэхүү ажиллагаанд мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамжийн талаарх тусгай мэдлэгийг ашиглах арга тактикийн асуудалд тусгайлан анхаарал хандуулсан судалгааны ажил төдийлөн олонгүй байхгүй байна. Ийм төрлийн бүтээлүүд үндсэндээ компьютерын техник, мэдээллийн асуудалтай холбоотой шинжээч томилох, шинжилгээ хийхтэй холбоотой асуудлуудыг авч үзсэн байдаг нь мөрдөн шалгах ажиллагааг гардан гүйцэтгэж байгаа эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд төдийлөн их ач холбогдолтой байж чадахгүй байна.

Иймд дээр дурдсан төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгайлсан мэдлэгтэй мэргэжилтнүүдийг татан оролцуулах тухай асуудлын мөн чанарыг тодорхойлох, оролцооны байж болох хэлбэрүүдийг тодорхойлон гаргах зайлшгүй шаардлага гарч байна.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн хууль зүйн мэдлэг боловсролын хүрээ, гадна орших мэдээллийн өндөр технологи, компьютерын программ хангамжтай холбоотой мэргэжлийн онцлог бүхий мэдлэг шаардагдсан асуудлыг тухайн салбарын тусгай мэдлэг боловсролтой мэргэжилтнүүдийг урьж оролцуулах, зөвлөгөө тусламж авах, албан ёсны дүгнэлт гаргуулах, бусад байдлаар татан оролцуулах арга замаар шийдэх боломж байна. Ийм төрлийн мэдлэгийг эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд тусгай мэдлэг гэсэн нэр томъёогоор нэрлэдэг. Энэхүү нэршлийн гол агуулга нь ямарваа гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шинжлэх ухаан техникийн ололтыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу ашиглахад оршиж байдаг.

Цахим орчинд интернэт сүлжээгээр мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамж ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүд, түүний дотор залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн, шинжээчдийн шинжлэх ухаан,

техникийн мэдлэг, мэргэшлийг ашиглах хэлбэрүүд нь дор дурдсан шаардлагыг хангаж байх ёстой гэсэн байр суурийг баримталж байна. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хэм хэмжээний хүрээнд байх;
2. Мэргэжилтэн, шинжээчийн тусламжтайгаар гарган авсан мэдээлэл нь эрүүгийн процессын ажиллагааны нотолгооны онол, арга зүйд нийцэж байх;
3. Мэдээлэл нь шинжлэх ухааны танин мэдэхүйн арга замаар тогтоогдож, гэмт хэргийн тухайлсан нөхцөл байдалд бүрэн нийцсэн тогтолцооны чиг хандлагыг хангаж байх ёстой.

Дээрх гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд шинжлэх ухаан, техник, мэдээллийн өндөр технологийн тусгай мэдлэгийг ашиглах үндсэн хоёр хэлбэр байдаг гэж үзэж болохоор байна. Тодруулбал,

Нэгдүгээрт: Эрүүгийн процессын хуульд заагдсан хэлбэр нь дотроо:

- a) Мөрдөн шалгах ажиллагаанд мэргэжилтнүүдийг оролцуулах;
- b) Эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх шатанд мэргэжилтнийг оролцуулах;
- c) Шүүх шинжилгээ явуулахад шинжээчийн дүгнэлт гаргуулах, түүнчлэн шинжээч, мэргэжилтнээс мэдүүлэг авах гэсэн төрлүүдтэй байна.

Хоёрдугаарт: Процессын бус буюу эрүүгийн процессын хуульд шууд тусгагдаагүй хэлбэр:

- a) хэргийг мөрдөн шалгаж байгаа эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн эсхүл шинжээч магадлагаа, зөвлөмжийн шинжтэй туслалцаа үзүүлэх;
- b) Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах ажиллагаанд шаардлагатай мэргэжилтнүүдийг татан оролцуулах;
- c) Аудитын шалгалт явуулах;
- d) Мөрдөн шалгах анхан шатны үйл ажиллагааны явцад гэмт хэргийн газар дээр материаллаг нөхцөл байдлын, тэрчлэн мөрдөн шалгах ажиллагааны цаашдын үе шатуудад эд мөрийн баримтын шинжилгээ судалгаа явуулах гэсэн төрлүүдтэй байна.

Эдгээрээс гадна цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны хувьд бол эрх бүхий албан тушаалтан мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамжийн салбарын мэргэжилтнүүдийн хамтарсан зөвлөгөөн хийх, гарын авлага, зөвлөмж гаргах, хамтын ажиллагааны практикт задлан шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын хамтын ажиллагааныхаа чиг хандлагыг хамтран тодорхойлох зэрэг арга хэлбэрийг сонгон хэрэглэж болох юм.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэг ашиглах хэлбэрийг ийнхүү хоёр бүлэг болгон хуваах объектив шалгуур бол тухайн мэдлэгийг ашигласнаар олж цуглуулсан үр дүнгийн өөрийнх нь шинж чанар юм. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэг бүхий мэргэжилтний ямар нэг оролцоотойгоор олж цуглуулсан, бэхжүүлсэн үр дүн нь нотолгооны ач холбогдолтой байх шаардлагатай бол энэхүү оролцоо зайлшгүй процессын хэлбэртэй байх ёстойг харуулна.

Цахим орчинд үйлдсэн залилан мэхлэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгайлсан мэдлэгтэй мэргэжилтнийг ашиглах дор дурдсан хэлбэрүүд байна¹. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагаанд мэргэжилтэн оролцуулах;
2. Шинжилгээ хийлгэх;
3. Мэргэжилтнүүдийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах;
4. Лавлагаа-мэдээлэл, зөвлөх үйлчилгээний туслалцаа авах;
5. Эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын үр дүнг ашиглах зэрэг багтаж байгаа юм.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгайлсан танин мэдэхүйн тусгай мэдлэг бүхий мэргэжилтнүүд нь тухайн гэмт хэргийн үйлдлийн онцлогоосоо шалтгаалан компьютерын техник, банк санхүү, бооцоот тоглоом, казиногийн техникийн ажилтан,

¹ Халтар, Т. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (кибер) гэмт хэргийг мөрдөн шалгах онцлог. УБ., 2019. 75-76 дах тал

цахим орчны өндөр технологийн сүлжээний мэргэжилтэн болон нийтийн дотор сошиал хэмээн нэрлэгдэх болсон олныг хамарсан цахим сүлжээний шаардлагатай хэмжээнд мэргэшсэн байваас зохино. Тэдгээр нь мөрдөн шалгах ажиллагаанд үйлдсэн гэмт хэргийн талаар ач холбогдол бүхий ул мөрийг илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагаанд тухайлбал, хэргийн газрын болон эд мөрийн баримтад хийх үзлэг хийхэд оролцох, компьютерын техник, мэдээллийн өндөр технологийн нэр томьёо болон өвөрмөц үг хэллэгийг тайлбарлах, зарим төрлийн нарийн төвөгтэй техникийн үйлдэл, программ хангамжийн талаар тайлбар, зөвлөмж өгөх, сэжигтэн, яллагдагчийн тухайлсан үйлдлийн талаар шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэнэ.

Мэргэжилтэн гэдэгт тодорхой төрлийн үйл ажиллагааны мэргэжлийн талаар орчин үеийн шинжлэх ухаан, техник болон бусад салбарын мэдлэг, туршлага, дадлага, чадвартай бөгөөд эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх болон энэхүү үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавих эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байгаа, тухайн хэргийн талаар нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх², шалгах, үнэлэх үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж байгаа этгээдийг ойлгоно.

Мөрдөн шалгах ажиллагаанд мэргэжилтэн оролцуулах шаардлага нь:

- 1) Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг үйлдсэн этгээдийн хувийн байдлын талаар урьдчилан тодорхойлох боломжтой мэдээллүүдийг олж авах;
- 2) Гэмт үйлдлийг илрүүлэх боломжтой газар орон ба цаг хугацааг тодорхойлох;
- 3) Гэмт үйлдлийн талаарх нотлох баримтын байж болох эх сурвалжийг олж тогтоох;
- 4) Мөрдөн шалгах ажиллагааны зарим нэг чухал төрлийг зохиох цаг хугацаа, газар орон, нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлох;
- 5) Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах шаардлагатай гэж үзэж байгаа криминалистикийн болон бусад техник хэрэгслийн загвар, ашиглах зорилго, тоо хэмжээ ба хариуцах эзний зайлшгүй оролцоо зэргээс үүдэлтэй байна.

Дээр дурдсан шаардлагаар дор дурдсан үйл ажиллагаа явуулах мэргэжилтнүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд татан оролцуулна. Үйл ажиллагааны чиглэл:

- 1) Цахим тооцооны техникийн засвар үйлчилгээ;
- 2) Мэдээлэл, технологийн сүлжээний салбар;
- 3) Мэдээлэл, харилцааны техник ажиллагаа, үйлчилгээ;
- 4) Цахим тооцооны техникийн тохиргоо, радио болон богино долгионы холбоо харилцаа;
- 5) Гааль, татвар, мэргэжлийн хяналт, санхүү нягтлан бодох бүртгэл;
- 6) Мэдээллийн дата төлөв, мэдээлэл хадгалалт, хамгаалалт, дамжуулалт;
- 7) Компьютерын программ хангамж, компьютерын сүлжээ хамаарах;

Эдгээр нь цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийн төрлийн тухайд давамгайлах шинжтэй байна.

Шинжилгээ хийлгэх нь цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тусгай мэдлэгийг ашиглах үндсэн хэлбэр нь болох юм. Үүнийг мөрдөн шалгах ажиллагааны практикт хоёр хэлбэртэй байж болно гэж судлаачид тодорхойлсон байна. Үүнд³:

1. Компьютер түүний дагалдах хэрэгсэлд шинжээч томилон шинжилгээ явуулах;
2. Тухайн компьютерт эсхүл ямар нэг мэдээлэл тээгчид хадгалагдаж байгаа мэдээллийг сэргээх, судлахад чиглэсэн техник, программ хангамжийн шинжилгээ явуулах хэлбэрүүд юм.

Харин зарим нэг эрдэмтэд тусгай мэдлэгийг дээрх төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах дөрвөн хэлбэр байна гэж үздэг байна⁴. Үүнийг тодруулбал,

- 1) Компьютер-техникийн шинжилгээ;

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйл Төрийн мэдээлэл. УБ. 2017. №23

³ Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа. УБ., 2019. 79 дэх тал

⁴ Рубцов, И.И. Криминалистическая характеристика преступлений как элемент частных методик расследования. СПб. 2001. 20-21 дэх тал

- 2) Программ хангамж техникийн шинжилгээ;
- 3) Мэдээлэл технологи, техникийн шинжилгээ;
- 4) Компьютерын сүлжээний шинжилгээ гэсэн төрлүүд байна.

Орчин үед цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн байдлаас дүгнэлт хийж үзэхэд гэмт этгээдүүд дан ганц интернэт сүлжээ ашиглаад зогсохгүй мөн түүнчлэн гар утас, хөдөлгөөнт холбооны бусад төрлүүд, хүмүүсийн банкны картын пин кодыг бичиж авах зорилготой далд байрлуулсан видео камер ашиглах нь ихсэж байгаа юм. Иймээс дээр дурдсан шинжилгээний дөрвөн төрлийг заримдаа дэс дарааллынх дагуу, заримдаа иж бүрдлээр нь ашиглах тохиолдол байнга гарах болсон учраас шинжилгээ хийлгэх тогтоолд шинжилгээний төрлийг нарийвчлан тухайлбал: “программ хангамж-техникийн тоон шинжилгээ явуулахыг...” гэх мэтээр нарийвчлан заах шаардлагатайг онцгойлон анхаарах ёстой болж байна.

Мөн түүнчлэн шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын тусгай мэдлэг бүхий мэргэжилтнүүдийн тухайлсан нэг хэргийн янз бүрийн нөхцөл байдлын талаар хамтран гаргасан дүгнэлт нь шинжээчид тавьсан асуулт нэг бүрийг тал бүрээс нь бүрэн дүүрэн хариулах боломжийг илүү олгоно гэсэн санааг эрдэмтэд онцгойлон заасан байна.

Нөгөө талаас цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тухайлсан салбарын тусгай мэргэжлийн шинжээчдийг заавал оролцуулах хэрэгцээ нь доорх хүчин зүйлстэй салшгүй холбоотой. Тухайлбал,

1) Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа этгээдүүд нь мэдээллийн өндөр технологийн салбарын гүн гүнзгий мэдлэг эзэмшсэн байх нь олон байдаг.

2) Ийм учир тухайн төрлийн гэмт хэргийн ул мөрийг олж илрүүлэхийн тулд тэднээс дутахааргүй мэдлэг, дадал эзэмшсэн хүн шаардлагатай болдог.

3) Компьютерын техник, мэдээллийн өндөр технологийн орчин үеийн хөгжлийн хурдац нь тухайн төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтны ажлынхаа байранд суралцан олж авч байгаа компьютерын техник, программ хангамжийн практик дадлагаас хавьгүй эрчимтэй явагдаж байгаа учраас тухайн салбарын өндөр мэдлэг, мэргэшил, дадлага чадвар эзэмшсэн мэргэжилтний туслалцаа зайлшгүй шаардлагатай болдог нөхцөл байдал юм.

Бодит байдалд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн эзэмшсэн мэдээллийн технологийн салбарын тусгай мэдлэгийн хүрээ нь цахим орчинд, интернэт сүлжээ ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн тухайн төрлийн гэмт явдлын талаар шаардлагатай сэжиглэл, таамаг дэвшүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад хүрэлцээгүй байж болох юм. Иймээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн хувьд түүний өөрт нь байгаа мэдлэг нь процессын бус эх сурвалжаас авагдсан онцгой шинжтэй мэдээлэл болохынхоо хувьд зөвхөн мэдээллийн өндөр технологийн тусгай мэдлэг бүхий мэргэжилтнийг мөрдөн шалгах ажиллагаанд тухайн салбарын тусгай мэдлэг бүхий мэргэжилтнийг татан оролцуулах тухай шийдвэр гаргах үндэслэл байх ёстой.

Танин мэдэхүйн бусад тусгай мэдлэг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах нь: Дээр дурдсанчлан, цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамжийн салбарын тусгай мэдлэгийг ашиглах энэхүү хэлбэр нь эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээгээр бус, харин эрх бүхий дээд шатны байгууллагын зааварт зааснаар мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн үзэмжээр шийдвэрлэгддэг асуудал учраас процессын бус хэлбэр хэмээн нэрлэгдэж байгаа юм.

Ийм хэлбэрээр тухайлсан салбарын тусгай мэдлэгийг ашиглах асуудал нь дор дурдсан байдлаар зохион байгуулагдаж болох юм гэж үзэж байна. Үүнд:

1) тухайлсан салбарын тусгай мэдлэг шаардлагатай асуудлаар мэргэжилтний зүгээс мөрдөн шалгах ажиллагааг явуулж байгаа эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчид зөвлөгөө өгөх;

2) Эрүүгийн процессын ажиллагааг явуулж буй албан тушаалтанд даалгаврын дагуу төрөл бүрийн лавлагаа гаргаж өгөх;

3) Шинжилгээг шинжилгээний бус байгууллагуудын яам, тусгай газрын хянан шалгах эрх бүхий байгууллага болон тусгай комиссын судалгаа, шалган нягтлах үйл ажиллагааны үр дүнг ашиглах;

4) Мэргэжилтэн техникийн чанартай тухайлбал, компьютерын программ хангамжийн хяналтын төхөөрөмжийг сэжигтэй этгээдийн компьютерт холбох гэм мэт туслалцаа үзүүлэх;

5) Хяналт шалгалт хийх эрхтэй байгууллага, хяналтын албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах;

6) Тухайн гэмт хэргийн эд мөрийн баримтын талаар урьдчилсан судалгаа шинжилгээ явуулсан шүүх шинжилгээний бус байгууллагын материалыг ашиглах зэрэг хамаарагдана.

Дээрх үйл ажиллагааг үндсэн гурван аргаар хэрэгжүүлж болох юм. Үүнд:

1) Тухайн салбарын тусгайлсан мэдлэг эзэмшсэн мэргэжилтнийг эрэн сурвалжлах ажиллагаанд урьж оролцуулах;

2) Лавлагаа мэдээллийн чанартай туслалцаа үзүүлэх;

3) Зөвлөх үйл ажиллагаа гэсэн аргууд багтана.

Тухайн салбарын тусгайлсан мэдлэг эзэмшсэн мэргэжилтнийг эрэн сурвалжлах ажиллагаанд урьж оролцуулах нь арга нь мөрдөн шалгах ажиллагааны практикт мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтны сэтгэл зүй, процесс ажиллагаанд чанартай ихээхэн ачаалал өгдөг байдал ажиглагдаж байгаа ба энэ нь компьютерын программ хангамжтай холбоотой чухал ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах, бэхжүүлэх, хураан авах ажиллагаа нь үлэмж хүндрэлтэй байдгаар тайлбарлагдаж байгаа юм.

Тусгай мэдлэг бүхий мэргэжилтний эрэн сурвалжлах ажиллагааны явцад гүйцэтгэх үндсэн үүрэг нь цахим орчинд интернэт сүлжээ ашиглан үйлдэж байгаа залилан мэхлэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд шийдвэрлэх ач холбогдолтой мэдээллийг байж болох дээд хэмжээнд олж авахад нь туслах явдал юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны тухайлсан үе шатанд тодорхой хэмжээгээр компьютер, бусад тусгай техник хэрэглэх асуудлыг нарийвчлан шийдвэрлэх, компьютерын техник, программ хангамжийн зохих мэдлэг, мэргэжил бүхий хөндлөнгийн гэрчүүдийг сонгон авах зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх асуудал түүний гүйцэтгэх үүрэгт шууд хамааралтай.

Тухайлсан салбарын тусгай мэдлэг бүхий мэргэжилтнийг урьж оролцуулснаар мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг дүгнэн үзвэл:

1) хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг гэмтээх, эсвэл устгах явдал гаргуулахгүй байх;

2) мэдээллийн үлэмж их урсгал ба хадгаламжийн санд зүг чиг зөв тодорхойлох, хэрэгтэй мэдээллийг цуглуулах, бэхжүүлэх, хураан авах;

3) Цуглуулан бэхжүүлсэн мэдээллийг криминалистик болон эрүүгийн процессын ажиллагааны шаардлагын үүднээс зөв тэмдэглэх, тээвэрлэх, хадгалах боломжтой болно.

Үүнээс гадна, цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь компьютерыг гэмт хэргийн үйл ажиллагаандаа мэдээлэл хадгалах, боловсруулах хэрэгсэл болгон ашиглаж байгаа гэж үзэх үндэстэй бол мөрдөн шалгах ажиллагаанд онц чухал ач холбогдолтой, хэрэглэгчдийн төлбөр тооцооны сүлжээнд ашигласан хорлонт программ хангамж, хуурамч гэрээ, хэлцлийн агуулгад холбогдох баримтууд болон бусад нотолгоог олж цуглуулах, бэхжүүлэх, хураан авах, хадгалах, нууцалсан тохиолдолд тайлж унших, сэргээх зэрэг үйл ажиллагаа нь тухайлсан салбарын тусгай мэдлэг бүхий мэргэжилтний туслалцаагүйгээр ямар ч үр дүнд хүрэхгүй гэдгийг үргэлж санаж байх ёстой.

Мэдээллийн өндөр технологи, компьютерын программ хангамжийн салбарын тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн нь зөвхөн нэгжлэг, хураан авах үйл ажиллагаа болон шүүх-шинжилгээнд оролцоод зогсохгүй, түүнчлэн сэжиглэгдэж байгаа хүнийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авах, техник хэрэгсэл, тусгай программ хангамж ашиглахтай холбоотой асуудлаар мэдүүлэг авахад үзүүлэх тусламж нь мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Мөрдөн шалгах ажиллагаанд татан оролцуулж байгаа мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамжийн тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн нь шүүх-

шинжилгээний албаны ажилтан биш бол эрх зүйн мэдлэг нь эрүүгийн процессын ажиллагаанд шаардлагыг хангадаггүй тул үйл ажиллагаандаа процессын алдаа гаргах эрсдэлтэй гэдгийг ямагт санаж байваас зохино. Үүнээс урьдчилан сэргийлэх үндсэн арга бол мөрдөн шалгах ажиллагааны тухайн төрлийг зохион байгуулахаас өмнө тусгай мэдлэг бүхий мэргэжилтний эрх, үүргийг нь маш нарийн тайлбарлаж өгөх, анхаарлыг нь гол зүйлд төвлөрүүлж өгөх үйл ажиллагаа байдаг.

Лавлагаа, мэдээллийн чанартай туслалцаа үзүүлэх арга нь үүсэн бий болсон байдлын талаар мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч, эрх бүхий албан тушаалтан үнэн бодитой төсөөлөл авах, цаашдын үйл ажиллагааныхаа талаар төлөвлөх, шаардлагатай шинжилгээ, судалгааны асуудлын хүрээг тодорхойлох, шинжээчид тавих асуултыг боловсруулах зэрэг чухал асуудлыг шийдвэрлэх үндэс суурь нь болно. Энэхүү аргын мөн чанар нь мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчийн зүгээс тусгай мэдлэг бүхий мэргэжилтэнд зориулсан асуултуудыг бичгээр тавьж, харин мэргэжилтэн ямар нэг тусгайлсан шинжилгээ судалгаа явуулалгүйгээр, тэдгээр асуултад хариулт өгөхөд оршино. Өгсөн хариулт нь лавлагаа болох ба тэрхүү мэдээлэл нь:

- 1) Картын сан, тухайлбал, хорлонт программ хангамжийн сан гэх мэт цуглуулгад төвлөрөх;

- 2) Мэдлэгийн ямар нэг салбарт ашиглагдах;

- 3) Мэргэжилтэн, нэг эсвэл хэд хэдэн салбарын танин мэдэхүйн мэдлэгийг ашигласан онцлог нь бусад салбаруудтай холбоотой асуудалд дам ашиглах зорилготойгоор хадгалагдана.

Зөвлөх үйл ажиллагаа нь тусгайлсан бэлтгэлтэй мэргэжилтнүүдийн зүгээс мөрдөн шалгах эрх бүхий субъектэд урьдчилсан байдлаар мөрдөн шалгах ажиллагаанд чухал гэж үзсэн мэдээллийг олж авахад нь тусалж байгаа мэдээлэл бөгөөд тухайлсан гэмт хэргийн ямарваа нэг нөхцөл байдлын талаар өгсөн дүгнэлт биш юм.

Шинжлэх ухаан техникийн ололт амжилт, мэдээллийн өндөр технологи, компьютерын техник, программ хангамжийн салбарт мэргэжлийн мэдлэг, ур чадвар ба тодорхой дадлага, тусгай мэдлэг, боловсрол эзэмшсэн хувь хүн цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр мөрдөн шалгах ажиллагааны өмнө тулгарсан эрхзүйн бус юмс, үзэгдлийг тайлбарлах үйл ажиллагаа явуулж байгааг зөвлөх үйл ажиллагаа гэж нэрлэнэ.

Энэхүү үйл ажиллагаа нь, юуны өмнө, мөрдөн шалгах ажиллагааны тактикийн асуудлыг шийдвэрлэхэд мөрдөн шалгах эрх бүхий субъектэд туслах, зарим төрлийн мөрдөн шалгах ажиллагааны төрлүүдийг зохион байгуулахад туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны явцад шинжилгээ хийлгэхээр шинжээч томилохын өмнө шинжилгээ томилох тогтоолд шинжээчид тавих асуултыг зөв оновчтой боловсруулах талаар мэргэжилтэнтэй зөвлөх нь чухал ач холбогдолтой. Энэхүү зөвлөгөө нь:

- 1) Ямар төрлийн шинжилгээ хийлгэх вэ?

- 2) Чухам ямар объектод шинжилгээ хийлгэх вэ?

- 3) Шинжээчид заавал тавих зохих ямар ямар асуулт байж болох вэ? гэдэг асуултад хариулт өгөхөд чиглэгдсэн байваас зохино.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тухайлсан салбарын тусгай мэдлэгийг ашиглах процессын бус хэлбэрийн өөр нэгэн түгээмэл төрөл бол гэмт хэргийн талаар ач холбогдол бүхий объектуудыг урьдчилан шинжлэх арга юм. Энэ аргын мөн чанар нь сэжиглэгдэж байгаа этгээдийн үйлдэл, үйл ажиллагаанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл байгаа эсэхийг тухайлсан салбарын тусгай мэдлэг ашиглан шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгаа эсэхийг шийдэх болон гэмт этгээдийг халуун мөрөөр нь илрүүлж баривчлахад тусгай мэдлэг бүхий мэргэжилтний ямар оролцоо, ямар арга барилаар хэрэгжих ёстойг тодорхойлоход оршино. Ийнхүү тодорхой болгосон мэдээлэл нь:

- 1) Цахим орчинд үйлдсэн залилан мэхлэгчийн гэмт үйл ажиллагааны хүрээ хязгаарын талаар илүү нарийн тодорхой төсөөлөл авах;

- 2) Гэмт санаа бодлоо хэрэгжүүлсэн арга барилын талаар нарийвчлан тодорхойлох;

- 3) Залилах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах;

4) Гэмт хэргийн нөхцөл байдлын онцлог шинжүүдийг тогтоох, гэмт этгээдийг илчлэх тогтоох, түүний залилах бусад гэмт хэрэг, нуугдмал үйлдлийг илрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж өгнө.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд авч үзэж байгаа асуудалтай холбоотойгоор нэр томъёоны талаар зарим нэгэн асуудлыг тодорхой болгох шаардлага гарч ирж байгаа юм. Эрдэмтэн судлаачдын бүтээлүүдтэй танилцаж байхад “тусгай мэдлэг” ба “тусгай танин мэдэхүй” гэсэн нэр томъёо аль аль нь хэрэглэгдсэн байна. Тэгэхдээ цаашид чухам аль нэр томъёог нь албан ёсоор хэрэглэх нь зохистой вэ? гэдэг асуудлыг нэг мөр шийдэх шаардлагатай. Учир нь:

1) Эрүүгийн процессын эрх зүйн практикийн хувьд “тусгай мэдлэг” гэдэг нэр томъёо нь “мэргэжилтэн” гэдэг тодорхой нэг субъекттэй хавсарсан утгаар хэрэглэгддэг учраас чухал ач холбогдолтой хэдий ч түүний талаар ямар нэг албан ёсны тайлбар байхгүй байна.

2) Хэрэв мэргэжилтэн мөрдөн шалгах ажиллагаанд шинжээчээр оролцох гэж байгаа бол түүний “тусгай мэдлэг” гэдэг нэр томъёоны агуулга давуу ач холбогдолтой байгаа бол харин мэргэжилтнийхээ хувиар тайлбар, мэдүүлэг өгөх гэж байгаа бол “тусгай танин мэдэхүй” гэдэг нэр томъёо түүний үйл ажиллагаанд илүү дүйх юм.

3) “Мэдлэг” гэдэг ойлголт нь “тухайлсан шинжлэх ухаан, техник, технологи, урлаг эсхүл урлан бүтээх үйл ажиллагааны салбар дахь тусгайлсан бэлтгэл эсвэл мэргэжлийн үйл ажиллагааныхаа мэдлэг, туршлага, дадлагын явцад олж авсан онолын мэдлэг, практикийн дадал чадамжийн тодорхой хэмжээний тогтолцоо” юм. Мэдлэг нэг талаасаа тухайн хүн эзэмшихэд бэлэн болсон мэдээлэл байдаг болохоор нэг эсхүл хэд хэдэн салбарын мэдлэгийг эзэмшсэн хүн нь мэргэжилтэн гэхээсээ мэдлэгтэй хүн хэмээн нэрлэгддэг.

4) “Танин мэдэхүй” гэдэг бол мэдлэг түүнийг хэрэглэх чадвар хоёрын хослол байдаг. Өөрөөр хэлбэл мэдлэгийг өөрийн болгоод практикт хэрэглэх боломжтой болсон байдал юм.

5) “Тусгай мэдлэг” гэдэг ойлголтыг эрдэмтэд “... шинжлэх ухааны бүтээл туурвил, ном, сурах бичиг, гарын авлага, заавар, журам зэрэгт дурдагддаг, шинжлэх ухаан, практикийн тодорхой салбарт олж авсан мэдээллийн тогтолцоо” хэмээн тодорхойлсон байна.

6) Харин “тусгайлсан танин мэдэхүй” гэдэг ойлголтыг “... тухайлсан ямар нэг тодорхой үйл ажиллагааны төрлөөр явагдсан онол, практикийн сургалтын үр дүнд хувь хүний олж авсан мэдлэг ба түүнийгээ хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай дадал чадвар” гэж судлаачид үзэж байна.

7) “Тусгайлсан” гэдэг тодорхойлолтыг олонх эрдэмтэд нэгдүгээрт: бүх хүн түгээмэл эзэмшээгүй мэдлэг өөрөөр хэлбэл, “өргөн дэлгэр хэрэглэгддэггүй”, “өдөр тутмын хэрэглээний бус”, “нийтийн хэрэглээнд тархаагүй” гэдэг утгаар, хоёрдугаарт: эрх зүйн бус салбарын мэдлэг гэж тооцож байна.

8) Тэгвэл төрөл бүрий лавлах, толь бичиг, цахим орчинд нийтэд илэрхий болж байгаа компьютерын техник, программ хангамжийн эсхүл мэдээллийн өндөр технологийн талаарх ямарваа нэг мэдээлэл нь “тусгайлсан” гэдэг шалгуурт хамаарах уу, үгүй юу гэдэг зүй ёсны асуулт гарч ирж байна.

Санал

“Тусгайлсан танин мэдэхүй” гэдэг ойлголтыг цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн тухайд илүү явцуу утгаар, тухайлбал, зөвхөн тухайлсан компьютерын техник эсхүл программ хангамжийн тухай хувь хүний мэдлэгийн шинж чанарыг харуулах бодит мэдээллийн тогтолцооных нь хүрээнд авч үзэхийг санал болгож байгаа юм. Үүнийгээ иш үндэс болгож цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн тухайд тодруулан авч үзэхэд:

“Тусгайлсан мэдлэг” гэж компьютерын техник, мэдээллийн өндөр технологийн салбарын мэргэжилтнүүдийн явцуу хүрээний тодорхой хэсэг нь эзэмшсэн, зөвхөн тэд мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглаж чадахаар гүнзгийрүүлэн судалсан мэдлэг чадвар мөн гэж тодорхойлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа. УБ., 2019. 79 дэх тал
2. Рубцов, И.И. Криминалистическая характеристика преступлений как элемент частных методик расследования. СПб. 2001. 20-21 дэх тал
3. Халтар, Т. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (кибер) гэмт хэргийг мөрдөн шалгах онцлог. УБ., 2019. 75-76 дах тал
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйл Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23